



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/152

Есөнбулаг

Газар эзэмших эрхийг бусдад  
шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Лхагвын Нэргүйбаатарын орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 8208001789 нэгж талбарын дугаартай 220 м2 газрыг иргэн Дамдинсүрэнгийн Чинбатад, Гоё дах ХХК-ний аж ахуйн зориулалтаар эзэмшиж байгаа 8208004669 нэгж талбарын дугаартай 1658 м2 газрыг иргэн Баатарын Ганзоригт эрх шилжүүлж, эзэмшил газрын хэмжээ, байршлыг хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.


2. Газар эзэмшсэн иргэний мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/634 дүгээр захирамжийн холбогдох хэсэг, 2018 оны А/310 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтын 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын Тамганы  
газар сарын 16-ны өдрийн 1/2 дугаар  
захирэмжийн хэвсрэлт

ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ  
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

д/д	Хуулийн этгээдийн нэр	Иргэн, аж ауйн нэгж байгууллагын регистрийн дугаар	Газар эзэмших ашиглах эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ (м.кв)	Нэгж талбарын хаяг	Газар эзэмшилтийн зориулалт	Газар эзэмших, ашиглуулах хугацаа
1	Д.Чинбат	ДЖ79022511	Эзэмших	8208001789	220	Оргил баг	Орон сууц (2203)	11
2	Б.Ганзориг	ДЭ65112019	Эзэмших	8208004669	1658	Харзат баг	Аж ахуйн (7003)	9